

2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу энэхүү үзэл баримтлалыг боловсруулан батлав.

1.1.Хууль зүйн үндэслэл

1.Монгол Улсын Үндсэн хуулийн “Монгол Улсын бүрэн эрхт байдал”-ыг тодорхойлсон Нэгдүгээр бүлгийн Хоёрдугаар зүйлд “1.Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.”, “2.Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.” гэж тунхагласан. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны ямар нэгжүүдэд хуваагдахыг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд **аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд** хуваагдана.” гэж заасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд зааснаар засаг захиргааны нэгжийг зөвхөн Үндсэн хуульд заасан хэлбэрээр байгуулна. Үүнээс өөр нэгжийг хууль, захиргааны актаар шинээр бий болгохыг зөвшөөрдөггүй. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд засаг захиргааны нэгжийг тодорхой, **хатуу байдлаар** тогтоосон нь төрийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилготой. Энэхүү тогтолцоонд хууль тогтоогч, захиргааны байгууллага дур мэдэн шинэ шатлал нэмэх, өөрчлөх эрхгүй.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь тухайн улсын нутаг дэвсгэрийг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор Үндсэн хуульд заасны дагуу **албан ёсоор тогтоосон, тодорхой эрх хэмжээ, чиг үүрэг бүхий нутаг дэвсгэрийн нэгж** бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг Үндсэн хуульд **шууд нэрлэгдсэн**, газар зүйн хувьд тодорхой хил хязгаартай, тухайн нутагт байнга оршин суугч хүн амтай, төрийн болон нутгийн захиргааны, нутгийн өөрөө удирдах байгууллага бүхий шалгуураар байгуулдаг.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн **11 дүгээр зүйлд** “11.1.Хороо нь иргэдэд хуульд заасан үйлчилгээ хүргэх, нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах чиг үүрэг бүхий анхан шатны нэгж мөн.” гээд “11.2.Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна. Хэсгийн хуваарийг хүн амын суурьшил, өрхийн тоог харгалзан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.” гэж заасан байна.

Мөн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна.” гэж заасан байгаа.

Нийслэлийн хорооны хэсгийг байгуулахдаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байгуулахад баримталдаг гол шалгуураар буюу хүн амын суурьшил буюу нутаг дэвсгэрийн байршил, хэмжээ, өрхийн тоог харгалзан тогтоохоор хуульчилсан. Ингэснээр хэдийгээр “Хэсэг” нь Монгол Улсын Үндсэн хуульд заагдаагүй атлаа хүн ам, өрхийн тоо, нутаг дэвсгэрт суурилсан албан ёсны “хуваарь”-аар тогтоогдож, энэ хэсэгт “ хэсгийн ахлагчийг” бий болгож тодорхой чиг үүргийг хариуцуулсан байна.

“Хэсэг” нь нэршлийн хувьд “зохион байгуулалтын нэгж” гэж тайлбарлагдаж болох боловч бодит байдал дээр:

- иргэдийн харьяаллыг тогтоож,
- захиргааны шийдвэр дамжуулж,
- хорооны чиг үүргийг тодорхой хэмжээнд орлон гүйцэтгэж байгаа нь

уг нэгжийг бодит байдлаар нь засаг захиргааны нэгж гэж дүгнэх хангалттай үндэслэл болно. Нөгөөтэйгүүр олон жил мөрдөж байсан практик болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд "хэсэг"-ийг засаг захиргааны нэгж биш, харин хорооны үйл ажиллагааг зохион байгуулах дотоод бүтэц (зохион байгуулалтын нэгж) гэж үзвэл засаг захиргааны бусад нэгжийн удирдлага, зохион байгуулалтыг тогтоодог нийтлэг зохицуулалтыг баримталж хуулийн хэрэгжилтийг нэг мөр, жигд хангах нь эрх зүйт төрийн зарчимд бүрнээ нийцэх болно.

Эцэст нь хураангуйлан хэлэхэд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн “Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна.” буюу хороо нь цаашаа "хэсэгт" хуваагдана гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Нийслэл -> Дүүрэг -> Хороо” гэсэн гурван шатлалыг дөрөв болгож, энэ нь иргэдийн аль байгууллагад хандах, хэн хариуцах нь тодорхойгүй болгоод, цаашлаад Үндсэн хуулиар баталгаажсан засаг захиргааны зарчмыг сулруулж байна.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлд нутаг дэвсгэрийнхээ иргэдэд хуульд заасны дагуу хүргэх үйлчилгээ, хууль тогтоомжид заасан болон өөрийн санаачилсан асуудлаар нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг санал, хүсэлтийг зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах ажлын зохион байгуулалт; хууль, зохих дээд шатны байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй тохиолдолд хорооны бие даан шийдвэрлэх нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой асуудал; нийтийн эзэмшлийн газар, зам талбайн газар зохион байгуулалт, орчны эрүүл ахуй, ариун цэврийн байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах ажил зэргийг Хорооны чиг үүрэгт хамруулсан.

Түүнчлэн хороодоос иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа захиргааны үйлчилгээнээс дурдвал оршин суугаа газрын бүртгэлтэй холбоотой тодорхойлолт, аж ахуйн нэгж, байгууллагуудтай холбоотой тодорхойлолт, лавлагаа гаргах, иргэдийн амьжиргаатай холбоотой нийгмийн чиглэлийн тодорхойлолт гаргах /жишээ нь их, дээд сургуульд тэтгэлэг хөтөлбөрт хамрагдах, аливаа тусламж,

дэмжлэгт хамрагдахыг хүсэх үед тухай иргэн, өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлсон, ам бүлийн мэдээллийг гаргаж өгдөг/, гэр бүлд чиглэсэн үйлчилгээ /үрчлэлийн асуудал, ахмад настны асран хамгаалах асуудал/, төрийн байгууллагаас гаргадаг судалгаа, мэдээ, мэдээллийг цуглуулах зэрэг болно.

Хороо болон хорооны Засаг даргын чиг үүрэгт хамаарах эдгээр асуудлаас “хэсгийн ахлагч” хууль тогтоомж сурталчлах, судалгаа, тоон мэдээлэл цуглуулах, орчны тохижуулалт, цэвэрлэгээнд иргэд, байгууллагыг татан оролцуулах, тухайн хэсгийн айл өрхөд мэдээ, мэдээлэл хүргэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байна.

Эдгээр чиг үүрэг нь тухайн шатны Засаг дарга, түүний ажлын албанд хамаарах боловч эдгээр байгууллага нь орон тооны хувьд хангалтгүй байгаагаас хамаарч энэхүү бүтцийг бий болгосон гэх үндэслэл давамгайлан гарч байгаа боловч иргэний эрх зүйн харилцааг зохицуулдаг Иргэний хуульд заасан Хөлсөөр ажиллах гэрээгээр гүйцэтгүүлж байгаа нь Төрийн албаны тухай хуультай нийцэхгүй байна. Товчхондоо, иргэний эрх зүйн гэрээ нь зах зээлийн харилцаанд зориулагдсан болохоос төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, иргэдийн хувийн нууцтай ажиллах суурь механизм байж болохгүй юм.

Төрийн албаны тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд авч үзвэл, төрийн үндсэн чиг үүрэгт хамаарах, мөн хувь хүний хувийн мэдээлэлтэй харьцах ажлыг иргэний эрх зүйн гэрээ (хөлсөөр ажиллах гэрээ)-ээр гүйцэтгүүлж байгаа нь хууль зүйн хувьд дараах зөрчлийг үүсгэж байна:

- төрийн захиргааны эрх мэдэл (мэдээлэл хүргэх, шаардах, цуглуулах) гэх мэт, түүний дотор хэсгийн ахлагч нар түгээмэл хийдэг гэх нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг иргэдэд мэдээлэх, таниулах ажил нь нэг талаас мэдээллийн шинжтэй боловч, нөгөө талаас төрийн шаардлагыг биелүүлэхийг шаардах эрх мэдэл ба *нийтийн эрх зүйн* харилцаа юм. Харин хэсгийн ахлагч нь өөрөө *иргэний эрх зүйн* гэрээгээр ажиллаж байгаа нь эрх зүйн чадамжийн хувьд зөрчилдөөн үүсгэж байна. Энгийнээр хэлбэл, төрийн албан хаагчийн орон тоог хэмнэх гээд төрийн эрх мэдлийг хувийн гэрээгээр ажиллаж байгаа хувь хүнд шилжүүлж болохгүй бөгөөд Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй.

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу иргэний эрүүл мэнд, гэр бүлийн байдал, хөрөнгө, бусад бүртгэлийн мэдээлэл нь хүний хувийн мэдээлэлд тооцогдох ба мэдээллийн аюулгүй байдлыг төр хариуцна. Хувийн мэдээллийг цуглуулах үүргийг хуулиар хамгаалагдсан, хариуцлага хүлээдэг төрийн албан хаагч хүлээх бөгөөд төрийн албан хаагч хууль зөрчвөл Эрүүгийн хууль болон Төрийн албаны тухай хуулиар хатуу хариуцлага (албан тушаалаас халах, төрд ажиллах эрхээ хасуулах г.м) хүлээдэг. Харин Иргэний хуулийн дагуу **хөлсөөр ажиллах гэрээтэй иргэн (хэсгийн ахлагч)** мэдээлэл задруулбал түүнд хүлээлгэх хариуцлага сул (гэрээ цуцлах, хохирол төлүүлэх төдий) байдаг. Төр иргэнийхээ хувийн мэдээллийг хамгаалах баталгааг гэрээт ажилтнаар дамжуулан хийж байгаа нь иргэний мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл учруулж байгаа үйлдэл юм.

Эдгээрийг дүгнэн үзвэл төрийн чиг үүргийг иргэний эрх зүйн гэрээгээр гүйцэтгүүлэх нь нэгд, Төрийн албаны тухай хуулийг тойрсон, хоёрт хувь хүний нууцад халтай, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чадахгүй, гуравт, хариуцлагын тогтолцоо сул зэрэг үр дагаврыг дагуулж байна.

3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.20 дахь заалтад “Хорооны Засаг дарга харьяалах хэсгийн ахлагч нарыг томилж, үйл ажиллагааг нь удирдах;” гэж заасан байна. Энэхүү бүрэн эрхийн дагуу хорооны Засаг дарга “Хорооны хэсгийн ахлагчийн ажиллах нийтлэг журам”-д заасан шалгуурыг хангасан иргэнийг сонгон шалгаруулалтгүйгээр, мэргэжлийн шалгалтгүйгээр, нийтэд зарлахгүйгээр шууд томилж байна. Ийнхүү томилж байгаа нь хөдөлмөрлөх эрхийн хамгаалалт сул, улс төрийн нөлөөллийн эрсдэлийг өндөр болгож байна.

Тухайлбал, хэсгийн ахлагч төрийн албан хаагч бус тул хорооны Засаг дарга өөрийн үзэмжээр сонгох, мэдээлэл, зар хүргүүлэх нэрийдлээр хэсгийн ахлагч нарыг сонгуулийн үйл ажиллагаанд ашиглах, Засаг даргын улс төрийн бүлэглэлд хамаарах хүмүүсийг давуу байдлаар томилох, Засаг дарга солигдох үед хэсгийн ахлагч нарыг чөлөөлөх үйл явц эрх зүйн хувьд ямар ч зохицуулалтгүй өрнөж байна.

Шүүхийн статистик мэдээллүүдээс үзэхэд орон нутгийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дараа хэсгийн ахлагч нартай холбоотой маргаан нэлээн гардаг байна. Тухайлбал, 2021-2024 онуудад жилд хэсгийн ахлагчтай холбоотой 30-50 хэрэг гарсан ба маргааны 70 хувь нь гэрээний хугацаа дууссан гэх үндэслэлээр хэсгийн ахлагчийг ажлаас нь чөлөөлж гэрээг дуусгавар болгосонтой холбоотой байна. Шүүх эдгээр нэхэмжлэлийн 70 гаруй хувийг хангаж шийдвэрлэсэн байх ба ийнхүү шийдвэрлэх үндэслэл нь гэрээний хугацаа дуусаагүй, хариуцагч болох дүүргийн Тамгын газар, хорооны Засаг дарга хууль зүйн тайлбар, үндэслэл гаргаж чадаагүй, хууль тогтоомж зөрчигдсөн байдал байна. Өөрөөр хэлбэл, бодит шалтгаан, байдал бол улс төрийн шалтгаан буюу шинэ Засаг дарга өөрийн хүмүүсийг томилж байна. Нөгөөтэйгүүр, хэсгийн ахлагчийн эрх зүйн байдал тодорхойгүй, хуулийн зохицуулалт байхгүйгээс болж тэдний эрх ашиг ч бас хохирч байна.

Товчхондоо төрийн анхан шатны үйлчилгээг үзүүлж байгаа хэсгийн ахлагч төрийн байгууллагуудын бүхий л судалгаа, мэдээллийг иргэдэд хүргэж ажилладаг, айл өрхүүдийн нийгмийн асуудлуудын судалгааг газар дээр нь явж гаргадаг, хог хүртэл ачилцдаг хэр нь төрийн үйлчилгээний албан хаагчийн тоонд ордоггүй, ажлын байр нь баталгаагүй, урамшууллын хэмжээ бага, нийгмийн халамжийн ямар ч дэмжлэггүй, улс төрийн нөлөөнд эмзэг зэрэг олон асуудал байна.

1.2.Практик шаардлага

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 37 дугаар тогтоолоор “Хорооны хэсгийн ахлагчийн ажиллах нийтлэг журам”-ыг баталсан ба энэхүү журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гэж бүртгээгүй байгаагаас хорооны хэсгийн ахлагч нарын үйл ажиллагаа эрх зүйн зохицуулалтгүй байна.

2025 оны 3 дугаар сарын байдлаар нийслэлийн 9 дүүргийн 204 хорооны 2,037 хэсэгт 1,915 хэсгийн ахлагч ажиллаж байна. Хэсгийн ахлагчийг хорооны Засаг дарга захирамж гарган томилж Хөлсөөр ажиллах 3 талт гэрээг дүүргийн Засаг даргын Тамгын газар, хорооны Засаг дарга болон хэсгийн ахлагч байгуулдаг байна.

2025 оны нийслэлийн төсвөөс дүүргүүдэд нийт 25.1 тэрбум төгрөгийг хэсгийн ахлагч нарт нэг сарын 1 сая төгрөгийн цалингийн зардалд хуваарилсан ба Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 25-ны

өдрийн шийдвэрээр хэсгийн ахлагчийн сар бүрийн 1,000,000 төгрөгийн урамшууллыг 200,000-аар нэмэгдүүлж, 1,2 сая төгрөг болгосон ба уг тогтоолыг 2025 оны дөрөвдүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үзэж байгаагаар хэсгийн ахлагч нарын урамшуулалд 3.8 тэрбум төгрөг нэмж зарцуулах нь 3 их наядын төсөвтэй нийслэлд өндөр ачаалал үүсгэхгүй гэж үзсэн байна.

Хэсгийн ахлагчдыг тухайн ажлыг эрхэлж байгаа хугацаа, насны байдлаар нь авч үзвэл нийт 1,915 хэсгийн ахлагчийн 33.6 хувь нь 25-40 хүртэлх насны, 55.5 хувь нь 41-60 насны, 208 буюу 10.9 хувь нь 60-аас дээш насныхан байна. Мөн хэсгийн ахлагчаар ажилласан хугацааг нь авч үзвэл 56.3 хувь нь 3 жил хүртэл, 20.8 хувь нь 3-5 жил, 14.5 хувь нь 5-10 жил, 8.4 хувь нь 10-с дээш жил хэсгийн ахлагчаар ажилласан байна.

Хэсгийн ахлагчид хууль тогтоомж сурталчлах, судалгаа, тоон мэдээлэл цуглуулах, орчны тохижуулалт, цэвэрлэгээнд иргэд, байгууллагыг татан оролцуулах, хэсгийн айл өрхөд мэдээ, мэдээлэл хүргэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байна. Эдгээр чиг үүрэг нь тухайн шатны Засаг дарга, түүний ажлын алба, Тамгын газарт хамаарах боловч эдгээр байгууллага нь орон тооны хувьд хангалтгүй байгаагаас хамаарч энэхүү бүтцийг бий болгосон гэх.

Хороодын хүн ам 1,000-аас 20,000 хүртэл ялгаатай (20 дахин) атал хэсгийн ажлын ачаалал тэнцвэргүй, үйлчилгээний чанар тэгш бус боловч хэсгийн ахлагчид ижил цалинтай байна.

Эдгээр байдлыг цэгцлэх үүднээс эхний ээлжид эрх зүйн зөрчлийг арилгах, хорооноос үзүүлж байгаа засаг захиргааны үйлчилгээнд дүн шинжилгээ хийж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнд:

- E-Mongolia, бусад цахим хэлбэрт шилжүүлэх;
- анхан шатнаас гаргуулдаг элдэв судалгаа, тоон мэдээллийг цөөрүүлэх;
- төрийн албаны тайлан, мэдээ, судалгааны удирдлагыг дахин re-engineering хийх;
- хороодын тоог нэмэх эсэх, эсхүл орон тоог нэмэх асуудлыг судалж хэсгийн ахлагч нарын эрх зүйн байдал хэт эмзэг байгааг өөрчилж хэсгийн ахлагч нарын үзүүлж байгаа үйлчилгээний эрэлт хэрэгцээг харгалзан төрийн үйлчилгээний албанд хамруулан баталгаат байдлыг нь хангаж улс төрийн хамаарлаас гаргах зэрэг.

Дээр дурдсан олон асуудлыг шийдвэрлэх практик шаардлагыг үндэслэн цахим засаглал (E-Mongolia) хөгжсөн үед хүний хүчин зүйлээр мэдээлэл дамжуулах хоцрогдсон аргыг халах, иргэний эмзэг мэдээлэлтэй харьцаж байгаа этгээдийг төрийн үйлчилгээний албан хаагчийн статустай болгож сахилга, ёс зүйн хэм хэмжээнд захируулах нь зүй есны хэрэг болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалт, 24 дүгээр зүйлд заасан “хуульд өөрчлөлт оруулах” хуулийн төсөл байна.

Хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйл болон Тавин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй зөрчилдөж байгаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.20 дахь заалтыг тус тус хүчингүй болгох, уг өөрчлөлттэй холбоотойгоор мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.9 дэх заалтад өөрчлөлт оруулах заалтыг тусгана. Мөн хуулийн төсөлд уг хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг заана.

Хуулийн төсөл нь дээр дурдсан өөрчлөлтүүдийг тусгасан 3 зүйлээс бүрдэнэ.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Нийслэлийн хороог “ зохион байгуулалт” хэмээн нэрлэн хэсэгт хуваарилсан нь зөвхөн техникийн асуудал биш, харин ардчиллын, хүний эрхийн, хууль ёсны засаглалын үндсэн асуудлууд юм. Үндсэн хуулийг зөрчиж байгаа практикийг үргэлжлүүлбэл хууль дээдлэх ёсыг алдагдуулж, иргэдийн итгэлийг бууруулж, авлига, улс төрийн нөлөөллийг нэмэгдүүлэн улс орныхоо олон улс дахь нэр хүндийг унагаах билээ. Иймээс нийслэлийн засаг захиргааны нэгж болох хороог хэсэгт хуваарилсан хуулийн заалтуудыг хүчингүй болгох, хасах өөрчлөлтийг оруулсан хуулийн төсөл батлагдсанаар:

- "Хэсэг"-ийн статусыг цэгцэлнэ.
- Хөлсөөр ажиллах гэрээгээр төрийн захиргааны чиг үүргийг гүйцэтгэхийг хориглоно.
- Иргэний эмзэг мэдээлэлтэй харьцаж буй этгээдийг Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилга, ёс зүйн хэм хэмжээг сахиулна,
- Цахим засаглал (E-Mongolia) хөгжсөн үед хүний хүчин зүйлээр мэдээлэл дамжуулах хоцрогдсон аргыг хална. Төрийн үйлчилгээ ил тод, цахим болсноор авлига, хүнд суртал 40%-аар буурч, иргэдийн төрд итгэх итгэл сэргэнэ.

Энэхүү хуулийн зохицуулалт нь Монгол Улсын засаг захиргааны нэгжийг Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн, төрийн үйлчилгээг улс төрөөс бүрмөсөн тусгаарлаж шат шатны сонгуулиар хорооны Засаг дарга өөрийн намын идэвхтнүүдийг хэсгийн ахлагчаар томилж, төрийн үйлчилгээгээр дамжуулан сонгогчдод нөлөөлөх "сүлжээ"-г устгахад чиглэгдсэн байна.

Улаанбаатар хотын 2000 гаруй хэсгийн ахлагчийн сарын урамшуулал болон үйл ажиллагааны зардалд жилд **28-29 тэрбум төгрөг** зарцуулж байна. Энэхүү зардлыг цахим системийг боловсронгуй болгоход нэг удаагийн хөрөнгө оруулалт хийж хорооны мэргэшсэн төрийн албан хаагчдын цалинг 30-50% нэмэгдүүлэх замаар ажлын бүтээмжийг өсгөхөд зарцуулах боломжтой.

Хууль баталсантай холбогдуулан нийслэлийн засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооноос үзүүлж байгаа төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, анхан шатнаас гаргуулдаг судалгаа, тоон мэдээллийг цөөрүүлэх, төрийн албаны тайлан, мэдээ, судалгааны удирдлагыг боловсронгуй болгох, түүнчлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, “Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолыг дагаж мөрдөх хугацааг хойшлуулсантай холбоотойгоор дүүрэг, хорооны чиг үүргийн уялдаа, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв, байгууллагын бүтэц, орон тоог чиг үүрэг нь хотод шилжүүлэхтэй холбогдуулан нийслэлийн хороодыг өөрчлөн зохион байгуулах, хороонд ажиллах төрийн албан хаагчийн орон тоог нэмэгдүүлэх, ингэхдээ төрийн үйлчилгээг төрийн албан хаагч хэрэгжүүлэх Төрийн албаны тухай хуулийн зарчмыг хангах зэргийг тусгасан үүрэг даалгаврыг Монгол Улсын Засгийн газарт өгөх тухай тогтоолын төслийг боловсруулна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хуулиудтай нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хууль баталсантай холбогдуулан “Хууль баталсан холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---oOo---